



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2023/11/-НА-СТА-ТШЗ

СОГТУУРАХ МАНСУУРАХ ДОНТОЙ ӨВЧТӨНГ АЛБАДАН ЭМЧЛЭХ,
АЛБАДАН ХӨДӨЛМӨР ХИЙЛГЭХ ГАЗРЫН 2022 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2023 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Ахлах аудитор Т.Майцэцэг

Утас: 70273465 Цахим хаяг: maitsetsegt@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	12
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал.....	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудитын талаар	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СМДӨАЭАХХГ	Согтуурах мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газар
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023.02.14 № 01/48
танай _____-ны № _____-т

СОГТУУРАХ, МАНСУУРАХ ДОНТОЙ
ӨВЧТӨНГ АЛБАДАН ЭМЧЛЭХ, АЛБАДАН
ХӨДӨЛМӨР ХИЙЛГЭХ ГАЗРЫН ДАРГА,
ХУРАНДАА Б.БАТТУЛГА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Согтуурах мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Согтуурах мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус газар нь архинд донтох эмгэгтэй этгээдийг албадан эмчлэх чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн байгууллага ба 2022 оныг "Цахимжуулалт, хөгжлийг дэмжих" жил болгон зарлаж, иргэдэд үзүүлэх үйлчилгээг цахимжуулах, алба хаагчдын мэдлэг ур чадвар, сахилга хариуцлагыг дээшлүүлэх, ногоон хөгжлийг дэмжих жил болгох зорилтыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Аудитын гол асуудал

Тухайн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл бүхий ажил гүйлгээ байхгүй байна. Тус газар нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор тайлант онд албан томилолтын зардлыг бүрэн хэмнэж бодит хэмнэлтийг бий болгосон байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно

G/Arkhiw/Aiban bichig 2023/ A4
19020040

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	282,391,916.50	114,339,993.25
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	30,000.00	30,000.00
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	30,000.00	30,000.00
31210	Төгрөг	30,000.00	30,000.00
31211	Төрийн сангийн харилцах	30,000.00	30,000.00
33	АВЛАГА	0	413,186.77
33500	Бусад авлага	0	413,186.77
33510	Байгууллагаас авах авлага	0	413,186.77
34	УРЬДЧИЛГАА	66,225,000.00	0
34600	Урьдчилж гарсан зардал	66,225,000.00	0
35	БАРАА МАТЕРИАЛ	216,136,916.50	113,896,806.48
35100	Түүхий эд материал	93,032,845.73	47,941,402.07
35110	Тусгай зориулалттай материал	17,868,830.00	19,280,648.16
35130	Эм боох материал	75,164,015.73	28,660,753.91
35400	Хангамжийн материал	123,104,070.77	65,955,404.41
35410	Бичиг хэргийн материал	405,133.50	568,360.00
35420	Аж ахуйн материал	42,427,186.32	47,188,007.40
35440	Түлш, шатах тослох материал	510,600.00	4,893,081.96
35450	Барилгын засварын материал	1,540,000.00	2,341,000.00
35460	Хүнсний материал	78,221,150.95	10,964,955.05
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	913,812,459.26	928,989,604.26
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	913,812,459.26	928,989,604.26
39200	Биет хөрөнгө	811,576,347.96	826,971,441.64
39201	Барилга, байгууламж, орон сууц	624,539,594.11	624,539,594.11
39202	Хуримтлагдсан элэгдэл	-80,126,469.23	-108,647,240.92
39203	Авто-тээврийн хэрэгсэл	76,833,333.00	108,708,332.80
39204	Хуримтлагдсан элэгдэл	-23,476,851.91	-52,480,324.09
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	371,428,445.22	358,366,503.82
39206	Хуримтлагдсан элэгдэл	-180,437,218.62	-141,823,348.36
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	61,196,770.35	49,241,256.94
39208	Хуримтлагдсан элэгдэл	-39,981,254.96	-12,533,332.66
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	1,600,000.00	1,600,000.00
39300	Биет бус хөрөнгө	102,236,111.30	102,018,162.62
39301	Програм хангамж	4,987,692.31	4,437,692.31
39302	Хуримтлагдсан элэгдэл	-4,751,581.01	-4,419,529.69
39303	Бусад биет бус хөрөнгө	102,000,000.00	102,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,196,204,375.76	1,043,329,597.51
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	30,000.00	30,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	30,000.00	30,000.00
41300	Өглөг	30,000.00	30,000.00
41360	Бусад өглөг	30,000.00	30,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	30,000.00	30,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,196,174,375.76	1,043,299,597.51
51	Засгийн газрын хувь оролцоо	1,196,174,375.76	1,043,299,597.51
51100	Засгийн газрын оруулсан капитал	512,937,694.90	512,937,694.90
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	512,937,694.90	512,937,694.90
51200	Хуримтлагдсан үр дүн	395,756,813.74	242,882,035.49
51210	Өмнөх үеийн үр дүн	888,281,491.30	395,756,813.74
51220	Тайлант үеийн үр дүн	-492,524,677.56	-152,874,778.25
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	287,479,867.12	287,479,867.12
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,196,204,375.76	1,043,329,597.51

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,049,131,860.44	1,174,859,029.15
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	23,041,160.44	116,484,129.15
120	Нийтлэг татварын бус орлого	23,041,160.44	116,484,129.15
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	960,000.00	44,075,751.20
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	210,000.00	175,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	750,000.00	43,900,751.20
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	12,550,000.00	45,556,299.80
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	9,531,160.44	26,852,078.15
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,026,090,700.00	1,058,374,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,006,090,700.00	1,050,374,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,006,090,700.00	1,050,374,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	20,000,000.00	8,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан	20,000,000.00	8,000,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,499,191,038.00	1,309,239,807.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,499,191,038.00	1,309,239,807.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,498,522,725.19	1,286,631,581.69
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	645,827,433.27	631,689,849.64
210101	Үндсэн цалин	390,298,900.00	377,201,750.58
210102	Нэмэгдэл	253,310,800.00	231,508,245.66
210104	Урамшуулал	2,217,733.27	22,979,853.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,056,800.00	21,675,618.65
210201	Тэтгэврийн даатгал	0	796,492.32
210202	Тэтгэмжийн даатгал	0	93,704.98
210203	ҮОМШӨ-ний даатгал	0	74,963.99
210204	Ажилгүйдлийн даатгал	0	13,709.56
210205	Эрүүл мэндийн даатгал	21,056,800.00	20,696,747.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	89,208,000.00	102,113,909.23
210301	Гэрэл, цахилгаан	39,000,000.00	47,752,913.23
210302	Түлш, халаалт	47,208,000.00	51,952,896.00
210303	Цэвэр, бохир ус	3,000,000.00	2,408,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	26,441,331.50	19,134,394.46
210401	Бичиг хэрэг	1,783,828.50	831,733.50
210402	Тээвэр, шатахуун	12,139,060.00	11,101,822.04
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,156,300.00	928,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,116,113.00	6,168,438.92
210408	Бараа материал акталсны зардал	3,246,030.00	104,400.00
2105	Нормативт зардал	306,782,159.42	265,378,557.71
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	183,910,194.48	129,502,461.81
210502	Хоол, хүнс	93,375,153.16	135,876,095.90
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	29,496,811.78	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	105,282,700.00	49,440,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,297,000.00	0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	296,600.00	241,900.00
210604	Урсгал засвар	95,689,100.00	49,199,000.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	196,573,722.00	69,278,920.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	193,968,868.00	67,266,720.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	784,000.00	658,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	293,200.00	246,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	30,000.00	25,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	918,200.00	771,700.00
210807	Газрын төлбөр	579,454.00	310,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	107,350,579.00	127,919,432.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,054,000.00	8,211,996.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	505,830.00	454,730.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	103,790,749.00	119,252,706.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	668,312.81	22,608,225.71
2132	Бусад урсгал шилжүүлэг	630,000.00	13,518,182.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	630,000.00	13,518,182.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	38,312.81	9,090,043.71
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	38,312.81	9,090,043.71
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-450,059,177.56	-134,380,778.25
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	42,465,500.00	18,494,000.00
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	42,465,500.00	18,494,000.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-492,524,677.56	-152,874,778.25

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,026,330,700.00	1,058,549,900.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	240,000.00	175,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	240,000.00	175,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	210,000.00	175,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	210,000.00	175,000.00
120009	Бусад орлого	30,000.00	0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,026,090,700.00	1,058,374,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,006,090,700.00	1,050,374,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,006,090,700.00	1,050,374,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	20,000,000.00	8,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан	20,000,000.00	8,000,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,001,179,261.48	1,012,719,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,001,179,261.48	1,012,719,800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,000,510,948.67	990,111,574.29
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	645,827,433.27	631,689,849.64
210101	Үндсэн цалин	390,298,900.00	377,201,750.58
210102	Нэмэгдэл	253,310,800.00	231,508,245.66
210104	Урамшуулал	2,217,733.27	22,979,853.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,056,800.00	21,675,618.65
210201	Тэтгэврийн даатгал	0	796,492.32
210202	Тэтгэмжийн даатгал	0	93,704.98
210203	ҮОМШӨ-ний даатгал	0	74,963.99
210204	Ажилгүйдлийн даатгал	0	13,709.56
210205	Эрүүл мэндийн даатгал	21,056,800.00	20,696,747.80

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	89,690,600.00	106,115,400.00
210301	Гэрэл, цахилгаан	39,000,000.00	48,166,100.00
210302	Түлш, халаалт	47,690,600.00	55,541,200.00
210303	Цэвэр, бохир ус	3,000,000.00	2,408,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,909,500.00	15,535,100.00
210401	Бичиг хэрэг	728,700.00	610,600.00
210402	Тээвэр, шатахуун	11,409,500.00	11,896,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,156,300.00	928,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал,	0	93,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,615,000.00	2,006,600.00
2105	Нормативт зардал	99,255,500.00	150,650,200.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	67,658,600.00	64,289,200.00
210502	Хоол, хүнс	31,596,900.00	86,361,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	116,611,861.40	50,241,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	19,548,961.40	0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	296,300.00	241,900.00
210604	Урсгал засвар	96,766,600.00	50,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,756,054.00	3,211,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,151,200.00	1,199,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	784,000.00	658,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	293,200.00	246,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	30,000.00	25,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	918,200.00	771,700.00
210807	Газрын төлбөр	579,454.00	310,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,403,200.00	10,992,006.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,845,800.00	10,536,806.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	557,400.00	455,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	668,312.81	22,608,225.71
2132	Бусад урсгал шилжүүлэг	630,000.00	13,518,182.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	630,000.00	13,518,182.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	38,312.81	9,090,043.71
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	38,312.81	9,090,043.71
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	25,151,438.52	45,830,100.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	25,121,438.52	45,830,100.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	25,121,438.52	45,830,100.00
2200	Дотоод эх үүсвэрээр	25,121,438.52	45,830,100.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	25,121,438.52	45,830,100.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-25,121,438.52	-45,830,100.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	30,000.00	0
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	30,000.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	30,000.00	30,000.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	512,937,694.90	287,479,867.12	888,281,491.30	1,688,699,053.32
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	512,937,694.90	287,479,867.12	888,281,491.30	1,688,699,053.32
9	Тайлант үеийн үр дүн	0	0	-492,524,677.56	-492,524,677.56
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	512,937,694.90	287,479,867.12	395,756,813.74	1,196,174,375.76
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	512,937,694.90	287,479,867.12	395,756,813.74	1,196,174,375.76
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	512,937,694.90	287,479,867.12	395,756,813.74	1,196,174,375.76
19	Тайлант үеийн үр дүн	0	0	-152,874,778.25	-152,874,778.25
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	512,937,694.90	287,479,867.12	242,882,035.49	1,043,299,597.51

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,050,549,900.00	1,041,459,856.29	9,090,043.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,050,549,900.00	1,041,459,856.29	9,090,043.71
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,037,016,100.00	1,027,941,674.29	9,074,425.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	638,971,400.00	631,689,849.64	7,281,550.36
210101	Үндсэн цалин	385,939,700.00	377,201,750.58	8,737,949.42
210102	Нэмэгдэл	250,775,700.00	231,508,245.66	19,267,454.34
210104	Урамшуулал	2,256,000.00	22,979,853.40	-20,723,853.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,461,800.00	21,675,618.65	1,786,181.35
210201	Тэтгэврийн даатгал	0	796,492.32	-796,492.32
210202	Тэтгэмжийн даатгал	0	93,704.98	-93,704.98
210203	ҮОМШӨ-ний даатгал	0	74,963.99	-74,963.99
210204	Ажилгүйдлийн даатгал	0	13,709.56	-13,709.56
210205	Эрүүл мэндийн даатгал	23,461,800.00	20,696,747.80	2,765,052.20
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	106,115,400.00	106,115,400.00	0.00
210301	Гэрэл, цахилгаан	48,166,100.00	48,166,100.00	0.00
210302	Түлш, халаалт	55,541,200.00	55,541,200.00	0.00
210303	Цэвэр, бохир ус	2,408,100.00	2,408,100.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,535,100.00	15,535,100.00	0.00
210401	Бичиг хэрэг	610,600.00	610,600.00	0.00
210402	Тээвэр, шатахуун	11,896,000.00	11,896,000.00	0.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	928,000.00	928,000.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон	93,900.00	93,900.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд	2,006,600.00	2,006,600.00	0.00
2105	Нормативт зардал	150,650,200.00	150,650,200.00	0.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	64,289,200.00	64,289,200.00	0.00
210502	Хоол, хүнс	86,361,000.00	86,361,000.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	96,072,000.00	96,072,000.00	0.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	45,830,100.00	45,830,100.00	0.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	241,900.00	241,900.00	0.00
210604	Урсгал засвар	50,000,000.00	50,000,000.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,211,500.00	3,211,500.00	0.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,199,300.00	1,199,300.00	0.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл	658,900.00	658,900.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	246,300.00	246,300.00	0.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	25,300.00	25,300.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	771,700.00	771,700.00	0.00
210807	Газрын төлбөр	310,000.00	310,000.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,998,700.00	2,992,006.00	6,694.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,543,500.00	2,536,806.00	6,694.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	455,200.00	455,200.00	0.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,533,800.00	13,518,182.00	15,618.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,533,800.00	13,518,182.00	15,618.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал	13,533,800.00	13,518,182.00	15,618.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,050,549,900.00	1,041,459,856.29	9,090,043.71
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,050,374,900.00	1,041,284,856.29	9,090,043.71
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,050,374,900.00	1,041,284,856.29	9,090,043.71
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	175,000.00	175,000.00	0.00
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос	175,000.00	175,000.00	0.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	20,000,000.00	8,000,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	20,000,000.00	8,000,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	20,000,000.00	8,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,000,000.00	8,000,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	20,000,000.00	8,000,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	20,000,000.00	8,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20,000,000.00	8,000,000.00
9	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	30,000.00
10	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	30,000.00	30,000.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Согтуурах мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газар нь архинд донтох эмгэгтэй этгээдийг албадан эмчлэх чиг үүрэг бүхий Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт тайлангаа нэгтгэдэг Хууль зүйн яамны харьяа төрийн байгууллага юм.

Согтуурах мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газар нь нь захиргаа, санхүү аж ахуйн алба, эмнэлгийн алба, харуул хамгаалалтын алба гэсэн 3 албатай, 49 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна.

Тус газар нь 2022 оныг "Цахимжуулалт, хөгжлийг дэмжих" жил болгон зарлаж, Иргэдэд үзүүлэх үйлчилгээг цахимжуулах, алба хаагчдын мэдлэг ур чадвар, сахилга хариуцлагыг дээшлүүлэх, Ногоон хөгжлийг дэмжих жил болгох зорилтыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Согтуурах, мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газар нь 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 зорилт, 30 арга хэмжээг хэрэгжүүлэхээр ШШГЕГ-ын даргатай 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр байгуулсан ба гүйцэтгэлийн хэрэгжилт 99 хувиар биелж, салбар нэгжээс тэргүүн байр эзэлсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Согтуурах мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газар нь үйл ажиллагаандаа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль зэргийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

"Төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн шинэ барилга бариулах ажлыг эхлүүлэх" арга хэмжээ нь Хууль зүй, дотоод хэргийн сайдын шийдвэрээр Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт баригдахаар шийдвэрлэгдэж, барилгын төслийн ажил хийгдэж байгаа нь тус байгууллага байршил өөрчлөгдөх магадлалтай гэж үзэж байна.

Тайлант хугацаанд байгууллагын хөдөлмөрийн дотоод журам болон холбогдох баримт бичигт өөрчлөлт оруулан мөрдөж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Согтуурах мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрын даргын 2022 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А/16 дугаар тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй дотоод хяналт, шалгалт явуулах комисс байгуулж шалгалт явуулах хуваарь баталсан байна. Төв аймгийн Согтуурах мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрын дотоод хяналтын ажлын хэсэг нь 2022 онд 13 ажил төлөвлөснөөс эмнэлгийн, сэтгэл зүйн, харуул хамгаалалт, санхүүгийн, дотоод ажлын албаны чиглэлээр шалгаж илэрсэн зөрчил дутагдлыг арилгах талаар тухай бүр хугацаатай үүрэг өгч хэрэгжилтийг тооцож ажилласан байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Согтуурах мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газар нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Согтуурах мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газар нь ШШГЕГ-ын даргын 2020 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн А/134 дүгээр тушаалаар батлагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Согтуурах мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газар нь 2022 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 153,288.0 мянган төгрөгөөр бууу 12,8 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	30.0	30.0	
Авлага	-	-	
Урьдчилгаа	66,225.0	-	(66,225.0)
Бараа материал	216,136.9	113,896.8	(102,240.1)
Үндсэн хөрөнгө	913,812.5	928,989.6	15,177.1
Нийт хөрөнгө	1,196,204.4	1,042,916.4	(153,288.0)
Өр төлбөр	30.0	30.0	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,196,174.4	1,042,886.4	(153,258.0)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,196,204.4	1,042,916.4	(153,288.0)

Дээрх хүснэгтээс харахад бараа материалын үлдэгдэл 113,896.8 мянган төгрөг болж 102,240.1 мянган төгрөгөөр буурсан нь Ар гүнт дэх сайн дурын эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн эмчлүүлэгчийн эм, хоол хүнсний материал зарцуулагдаж дууссан. Тайлант онд эмчлүүлсэн эмчлүүлэгчийн тоо өмнөх онтой харьцуулахад 25 хувиар өссөнтэй холбогдон бараа материалын зарцуулалт өссөн.

Үндсэн хөрөнгө 928,989.6 төгрөг болж 15,177.1 төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 45,830.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан, анги салбар, ерөнхий газраас үнэ төлбөргүй 88,599.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө авсан, мөн үндсэн хөрөнгө акталснаас болж шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 8,552,814.2 мянган төгрөг, үйл ажиллагааны орлого байхгүй, нийт зарлагыг 8,552,814.2 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

ШШГЕГ-ын даргын 2021 оны 12 дугаар сарын 22-ний “2022 оны төсөв батлах тухай” А/205 дугаар тушаалаар тус байгууллагын төсвийн төслийн саналаас 7,628,562.4 мянган төгрөгөөр зардлыг бууруулж 924,251.8 мянган төгрөгөөр баталсан байна.

Согтуурах мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрын шинэ барилга 6,002,828.2 мянган төгрөгийг болон төсвийн төсөлд тусгасан зардлаас цалин хөлс 420,655.1 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 57,037.2 мянган төгрөг, хангамж бараа материалын зардал 38,014.9 мянган төгрөг, эм, эмнэлгийн хэрэгслийн зардлыг жишиг нормативын дагуу олгоогүйгээс 707,215.8 мянган төгрөг, эд хогшил урсгал засварын зардал 332,051.4 мянган төгрөг зэрэг зардлыг бууруулсантай холбоотой байна.

Тайлант хугацаанд батлагдсан төсөв хүрэлцэхгүйгээс ШШГЕГ-ын санхүү, үйлдвэр хөрөнгө оруулалтын газарт хүсэлт явуулж, батлагдсан төсөвт 4 удаа өөрчлөлт хийгдсэн байна.

Энэ нь 2022 оны 3 дугаар сард төсвийн хэмнэлттэй холбоотойгоор батлагдсан төсвийг 20 хүртэл хувиар бууруулж, 916,314.7 мянган төгрөгөөр баталснаас төсөв хүрэлцэхгүй, өр үүсэх нөхцөл бүрдсэнээс санал хүргүүлж нэмж, тодотгон төсвийн хуваарьт өөрчлөлт оруулснаас шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 126,123.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 1,050,374.9 мянган төгрөгөөр тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх нэг хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,050,374.9 сая төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,050,374.9 мянган төгрөгийн санхүүжилт, үйл ажиллагааны орлого 175.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,041,459.8 мянган төгрөг буюу 99,2 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг 9,090.1 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх нэг хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,050,374.9 мянган төгрөгийг улсын төсвөөс 100 хувь санхүүжүүлж, үйл ажиллагааны орлогоор 175.0 мянган төгрөгийг төвлөрүүлэн, оны эцэст зарцуулаагүй үлдэгдэл 9,090.1 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	1,036,841.1	1,027,766.7	9,074.4	99,1%
2	Туслах үйл ажиллагааны орлого	0.0	175.0	175.0	100%
3	Ажил олгогчоос олгох тэтгэмж	13,533.8	13,518.1	15.7	99,8%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Согтуурах мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газар нь тайлант онд ШШГЕГ-аас шилдэг салбар нэгжээр шалгарч тэргүүн байрны шагнал 8,000.0 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтийн дансаар зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт шүүхийн шийдвэр гүйцэтгэл 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Хэрэгжилт нь дутуу болон хангалтгүй байгаа төсөл хөтөлбөр байхгүй.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/						
№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70705 шүүхийн шийдвэр гүйцэтгэл	1 жил	Байгууллагын хэвийн үйл ажиллагаа хангагдана.	99,2%	1,050,374.9	1,041,459.8

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Согтуурах мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Майцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Согтуурах мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газар нь 2022 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайланг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/51 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр ШШГЕГ-ын 2022 оны баталсан төсвийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Согтуурах мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрын батлагдсан төсвийн 2022 оны нийт зарлага 996,118.4 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 14,941.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 11,206.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ШШГЕГ-ын даргын “Төсвийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 2022 оны 02 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг тооцон, санхүүгийн сахилга батыг дээшлүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлж, төрийн хэмнэлтийн тухай хуулийг үйл ажиллагаандаа мөрдөн ажилласан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор ШШГЕГ нь 2022 оны 3 дугаар сард батлагдсан төсвийг 20 хүртэл хувиар бууруулж баталсан. Тайлант онд тус газарт албан томилолтын зардлыг батлаагүйгээс тус зардал бүрэн хэмнэгдэж, 1,260.0 мянган төгрөгийн бодит хэмнэлтийг бий болгосон байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Согтуурах мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 17 орлогын, 24 зарлагын мөнгөн гүйлгээг болон өмч хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийг хугацаандаа байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Согтуурах мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрын эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдсэн.

Завсрын аудитаар өгөгдсөн зөвлөмжийн биелэлтийг 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдөр ирүүлсэн, биелэлтийг хянахад зөвлөмжийг хэрэгжүүлэн эмийн үлдэгдэл зөрүүтэй байсанд эмнэлгийн хэрэгсэлд тавих хяналтыг чангатган өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтад гэнэтийн байдлаар тооллогыг 5 удаа хийхэд алдаа зөрчил илрээгүй шалгагдсан байна.

Мөн эмийн сангийн үлдэгдлээс 14 нэр төрлийн эмийг сонгон тоолоход 4 нэр төрлийн эмийн зөрүү 524.1 мянган төгрөгийг эмийн санчаар төлүүлж, зөрчлийг арилгасан тухай даргын 2023 оны 02 дугаар сарын 9-ны өдрийн 01/80 дугаартай албан бичгээр ирүүлсэн тул аудитын тайланд тусгах шаардлагагүй гэж үзлээ.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 албан шаардлага, 1 зөвлөмж өгөгдсөнийг 100% хэрэгжүүлэн, биелэлтийг 2022 оны 6 дугаар сарын 3-ны өдөр 01/576 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	2	4,606.1	2	4,606.1	100
Зөвлөмж	1	47,649.5	1	47,649.5	100
Нийт дүн	3	52,255.6	3	52,255.6	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Согтуурах мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрын дараагийн аудитаар урсгал засварын зардлаас хийгдсэн сангийн засварын ажлын гүйцэтгэлд анхаарал хандуулах нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 413.2 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 413.2 мянган төгрөгийн алдааг залруулав.

Тайлант оны цахилгааны зардлаас 413.2 мянган төгрөг илүү шилжүүлж, зардалд бичсэн зөрчил илэрлээ. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу залруулга хийгдсэн.

Аудитаар нийт 10,212.0 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 10,212.0 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлсэн.

5.2 Албан шаардлага

Тус газрын бараа материалын үлдэгдлийг тулгахад нэг удаагийн 10,212.0 мянган төгрөгийн үнийн дүн бүхий 809 ширхэг оношлуур үлдэгдэлтэй байна. ШШГЕГ-аас тус газраас хэрэгцээ шаардлагатай материалын захиалгаагүйгээр 2022 оны 10 дугаар сарын 19-нд 12500 төгрөгөөр 200 ширхэг, 2022 оны 12 дугаар сарын 01-нд 11500 төгрөгөөр 500 ширхэг нэг удаагийн оношлуурыг үнэ төлбөргүйгээр нийлүүлж, нөөцөлсөн зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх" гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны 95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл, зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Нөөц	1	10,212.0			1	10,212.0						
Дүн	1	10,212.0			1	10,212.0						